

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

№	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Дүүргийн төсвөөс нийслэлд төвлөрүүлэх орлогыг энэ долоо хоногт багтаан танилцуулж, нийслэлийн төсвийн тодотгол хийх бэлтгэл ажлыг хангах.				
1	Нийслэлд нийт төвлөрүүлэх 142,9 тэрбум, үүнээс 1 дүгээр улиралд 47,8 тэрбум төвлөрүүлэхээс 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар 35,9 тэрбум төгрөг төвлөрүүлж 75 хувийн гүйцэтгэлтэй байна. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 30 дугаар тогтоолоор Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан батлуулав.			
Үүрэг даалгавар ХОЁР: 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Өглөөний цэвэрлэгээ”-г 20 байршилд зохион байгуулж, шинээр ирж буй хотын нийтийн аж ахуйн машин тоног, төхөөрөмжийг хүлээлгэж өгөх, цаашид ашиглалтыг бүрэн хариуцуулж ажиллах.				
2	2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Өглөөний цэвэрлэгээ”-г шинэ машин техникээр 20 байршилд зохион байгуулах төлөвлөгөөтэй байсан боловч тодорхой шалтгааны улмаас хойшлогдон тухайн цэвэрлэгээ үйлчилгээ хийгдээгүй болно.			
Үүрэг даалгавар ГУРАВ: Хотын нийтийн аж ахуйн байгууллагуудад ажиллаж байгаа ажилчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх тооцоо, судалгааг хийж, зохион байгуулах. Үүнд: Эхний ээлжид Дүүргүүдийн ТҮК болон Хот тохижилтын газар, Дараагийн үе шатанд нь: Геодези, усны барилга байгууламжийн газар, Орон сууцны удирдах газар, Ус сувгийн удирдах газар гэх мэт				
3	Дүүргийн ИТХ-ын 2024 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар Засгийн газрын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон тогтоолын дагуу Дүүргийн нийт ажилтан албан хаагч нарын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг шинэчлэн тооцож Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан батлуулав. Хотын нийтийн аж ахуйн байгууллагуудад ажиллаж байгаа ажилчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэхтэй холбоотой тооцоо судалгааг гаргаж нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн Б.Мөнхбаярт 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр ERP цахим хаягаар хүргүүлсэн болно.			
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/367 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрлийн болон бусад шон дээгүүр татсан кабел утсыг цэгцлэх ажлуудыг шуурхай зохион байгуулж, интернэт сүлжээний байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж, Захирамжийн хүрээнд хийсэн ажлын үр дүнг олон, нийтэд мэдээлж ажиллах.				
4	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/367 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээ хариуцсан Соёндрийм ХХК чингэлтэй Хайлааст гудамжны 200 м кабелиг цэгцэлсэн.			

	Дүүргийн Газар зохион байгуулалтын алба: Нийслэлийн Засаг даргын А/367 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдыг 5 бүрэлдэхүүнд хуваан 2024 оны 04 дүгээр сарын 02-ноос 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд нийслэлийн 6 дүүргийн нутаг нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж талбайд хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартыг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар зөрчлийн судалгааг гаргаж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газрын кадастрын хэлтэст хүргүүлсэн. Үүнд: 1. Зөвшөөрөлтэй талбай хэмжээнээсээ илүү гаргаж хашаа барьсан-56 нэгж талбар 2. Зөвшөөрөлгүй газар эзэмшиж байгаа-4 айл өрх 3. Зөвшөөрөлгүй ТҮЦ-15 Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас дээрх 56 нэгж талбар болон зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа 15 ТҮЦ-т газрын зөрчил арилгах хугацаатай мэдэгдэл хүргүүлэн ажилласан. Үүнээс 2 иргэн хуулийн этгээд илүү хашсан талбайгаа өөрсдөө чөлөөлөх хүсэлтэй байгаагаа тус албанд ирүүлээд байна.			
Үүрэг даалгавар ТАВ: Нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулж дуусгах, худалдан авах ажиллагааны явцыг өмнөх онтой харьцуулан, үр дүнг танилцуулах.				
5	Тус алба нь 2023-2024 он дамжин хэрэгжих болон 2024 онд шинээр хэрэгжих Төсвийн ерөнхийлөн захирагчийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 100, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/238 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Захиалагчаас ажлын тоо хэмжээ, зураг төсөв ирүүлсэн 58 ажлын худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зохион байгуулж байна.Үүнээс, гэрээ байгуулагдсан 32, гэрээ байгуулах эрх олгосон 3, тендер зохион байгуулалтын шатанд 17, ажлын тоо хэмжээ ирүүлээгүй 36, шууд худалдан авалт хийх 7 төсөл арга хэмжээ байна. Тендер шалгаруулалт удаа дараа амжилтгүй болсон 6 төсөл, арга хэмжээний зураг төсвийг хянуулахаар захиалагчид хүсэлт гарган ажиллаж байна.			
Үүрэг даалгавар ЗУРГАА: Боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааг эрчимжүүлж, дүүргүүдийн нутаг дэвсгэрт хийгдэж дуусаагүй Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгын ажил, цаашид авч хэрэгжүүлэх, арга хэмжээний талаар Нийслэлийн Удирдах ажилтнуудын Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах.				
6	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 10 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс: Бэлтгэл шатандаа-1 Тендерийн шатандаа-2 Газар чөлөөлөлтийн шатандаа-2 Гэрээ байгуулан хэрэгжиж байгаа-5 Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/77 дугаар тушаалаар дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн явцад хяналт тавин ажиллах ажлын хэсэг байгуулагдсан.			

	Тус ажлын хэсэг нь 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр болон 18-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явцад газар дээр нь очиж шалгаж үнэлгээ хийж гэрээнд заасан хугацааг баримтлахгүй, ажлын явц удаашралтай байгаа нийт 7 гүйцэтгэгч компанид “Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэн ажиллаж, ажлын явцын дэлгэрэнгүй тайлан ирүүлэх тухай 2024 оны 3/868, 3/986 тоот албан бичгүүдийг хүргүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарын нийт 13 төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 “Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 30 дугаар тогтоолд тусгуулсан.			
Үүрэг даалгавар ДОЛОО: Худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа байгууллагууд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль, журамд нийцүүлэн, ил тод нээлттэй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулахад анхаарч ажиллах.				
7	Тус алба нь хуулийн хэрэгжилтийг ханган тендер шалгаруулалтын урилга, нээлт, үр дүнгийн мэдээллийг хуулийн хугацаанд төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, дүүргийн цахим хуудаст нийтлэн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Үнэлгээний хороонд ажиллах захиалагчийн төлөөлөл, хөндлөнгийн төлөөллөөр тухай бүр Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдүүлгийг бөглүүлэн, холбогдох хууль журмыг тогтмол танилцуулах талаар үнэлгээний хорооны нарийн бичгүүдэд үүрэг болгосон.			
Үүрэг даалгавар НАЙМ: Нийслэлийн хэмжээнд Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулж, гал унтраах робот худалдан авах ажлыг судалж зохион байгуулах.				
8	Дүүргийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” А/95 дугаар захирамжийн хүрээнд Засаг даргын нөөц хөрөнгөөс 9,790,000 мянган төгрөгийг шийдвэрлүүлэн Онцгой байдлын хэлтсийн бэлтгэл ээлжийн 12 алба хаагч, Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн 1 гишүүн 2 автомашинтайгаар хөдөлгөөнт эргүүлийн үүргийг 2 удаа дүүргийн 23,24 дүгээр хорооны Ногоон бүсэд амарч, зугаалж байгаа 300 иргэнд “Шар өвс болон ой хээрийн түймэр”-ийн аюулаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг 300 ширхгийг тарааж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Гал унтраах робот худалдан авах ажлыг 2025 оны улсын төсөвт тусгуулах саналыг дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.			